


ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ

ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

**Санхүүгийн хяналт, аудитын албаны
Дарга Б.Саранчимэг**




Хуулийн төсөл өргөн баригдав.
2017.02.10



Хуулийг хэлэлцэж байгаа байдал.
2017.12.07

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 12 гишүүн 2017.02.10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017.12.07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ



ШИНЭЧЛЭЛИЙН ЗОРИЛГО



- НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ
- ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ
- ИРГЭДЭД ХҮРЭХ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ

Хууль батлагдан гарах практик шаардлага.

Төрийн албаны тухай хууль боловсронгуй болсон хэдий ч төрийн албаны үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байдал гарсаар байна. Тухайлбал:

- ✓ Төрийн албаны хүний нөөцийн бодлого тогтворгүй, *албан тушаалд тавигдах шаардлага тодорхойгүй, төрийн албан хаагчийн албан тушаал /ажлын байр/ баталгаагүй*, улс төрийн нөлөөлөлд автах, бие даасан хараат бус байдлаа хангаж чадахгүй байдал үргэлжилсээр ирсэн,
- ✓ Улс төрийн албан тушаалтнаас бус төрийн албан хаагч нар өөрсдөө улс төрийн нөлөөнд автдаг,
- ✓ Мэдлэг чадварт тулгуурласан **“Мерит”** буюу **“Чадахуйн зарчим”**-д суурилсан, сонгон шалгаруулалтын тогтолцоог хэвшүүлэх, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг хөгжүүлж, бэхжүүлэх түүний эрх зүйн үндсийг хуульд тусгах,
- ✓ Төрийн албан хаагчийн алдааны улмаас улсын төсөвт тооцоолоогүй эрсдэл үүсч байгаа, /үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн г.м/
- ✓ Бүх шатны төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшлийн багц сургалт

Хуулийн төслийн үзэл баримтлал.

Хууль зүйн үндэслэл 1: Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг: ”Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”

Хууль зүйн үндэслэл 2:
Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан
“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”

3.3.2.3.төрийн бодлогын залгамж чанарыг хангах эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.

3.3.2.6.төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.2.7.төрийн албан хаагчид аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрдүүлж, сонирхлын зөрчлийг хуулиар хязгаарлана.

Хуулийн төслийн үзэл баримтлал.

Чадахуйн зарчим **/МЕРИТ/** буюу иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хуулиар тодорхойлж мэдлэг, чадвартай иргэдэд нээлттэй **/КАРЬЕРЫН ШАТЛАН ДЭВШИХ ТОГТОЛЦОО/** өрсөлдөөнөөр төрийн албанд орох боломж олгохын зэрэгцээ төрийн албанд нэвтрүүлнэ.

Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнд тавих хяналтыг сайжруулж, хариуцсан ажил, үйлчилгээ, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулсан албан хаагчид хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Төрийн албан хаагч /улс төрийн албан хаагчаас бусад/ улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцох явдлыг таслан зогсоож, улс төрийн нөлөөнөөс ангид, ард түмнийхээ тусын тулд, зөвхөн төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах Үндсэн хуулийн үзэл санаа бодитоор хэрэгжих боломжтой болно.

Удирдлагын академийг төрийн албан хаагчдын тасралтгүй үргэлжлэх сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулагч, судалгаа, сургалт, эрдэм шинжилгээ, арга зүйн хүрээлэн болгон өөрчилж, чадавхийг бэхжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Төрийн албан тушаалтан хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

Мөн ажлын гүйцэтгэл, үр дүнгээр нь төрийн албан хаагчдыг урамшуулах, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэнэ.

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ✓ Харьцангуй баталгаатай албан тушаал
- ✓ Улс төрийн шалтгаанаар чөлөөлөгдөхгүй
- ✓ Бүтцийн өөрчлөлтөөр халагдахгүй
- ✓ Орох босго өндөр
- ✓ Гарах хаалга харьцангуй хязгаарлагдмал
- ✓ Иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх
- ✓ Олон нийтийн итгэл дэмжлэгэд тулгуурлах
- ✓ Алагчлахгүй ялгаварлахгүй байх



ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН БҮТЭЦ, ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017.12.07-ны өдөр батлагдан **2019.01.01**-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын гол үзэл санаа нь **“ШИНЭ ХУУЛИЙГ ХУУЧИН ОЙЛГОЛТООР ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ”** байх



ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН БҮТЭЦ, ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА



• 1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Төрийн алба

• 2 ДУГААР ХЭСЭГ

Төрийн албан тушаалд тавих шаардлага, төрийн албан тушаалд томилох журам, төрийн албаны шалгалт

• 3 ДУГААР ХЭСЭГ

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг, нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйл, ёс зүйн хэм хэмжээ

• 4 ДҮГЭЭР ХЭСЭГ

Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа

• 5 ДУГААР ХЭСЭГ

Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн

• 6 ДУГААР ХЭСЭГ

Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийгмийн баталгаа

• 7 ДУГААР ХЭСЭГ

Төрийн албаны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

Хууль хоорондын уялдааг маш сайн хангасан



- **Агуулга**

Хууль хоорондын уялдааг маш сайн хангасан бөгөөд дагаж мөрдөх журам, Засгийн газрын тогтоолууд шинэчлэгдэнэ. Тухайлбал:Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоол /албан тушаалын нэр нэршилтэй холбоотой/

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

3 дугаар зүйлд нэр томьёоны шинэ тодорхойлолтууд орсон.

6.1.төрийн албыг доор дурдсанаар ангилна.

- 6.1.1.төрийн улс төрийн алба
- 6.1.2.төрийн захиргааны алба
- 6.1.3.төрийн тусгай алба
- 6.1.4.төрийн үйлчилгээний алба

Шинэ зохицуулалт

18.1.төрийн захиргааны албан тушаалыг доор дурдсанаар ангилна

- 18.1.1.тэргүүн түшмэл
- 18.1.2.эрхэлсэн түшмэл
- 18.1.3.ахлах түшмэл
- 18.1.4.дэс түшмэл
- 18.1.5.туслах түшмэл

3.1.3. **“Чадахуйн зарчим /мерит/”** гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг,

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“төрийн алба” гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг;

3.1.2.“төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг;

3.1.3.“чадахуйн зарчим /мерит/” гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршилага, ажлын үр дүнд тулгуурлахыг;

3.1.4.“сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг;

3.1.5.“албан тушаалын тодорхойлолт” гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршилага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

• **Улс төрийн албан тушаал** эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг,

Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар,

• **Үйлчилгээний албан тушаал** эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар,

• Төрийн албан хаагчийн **хөдөлмөрийн харилцаатай** холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг **Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар**,

• Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг **энэ хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар**,

• **Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгчийг** томилж, чөлөөлөх асуудлыг холбогдох хуулиар

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭГ ЗҮЙЛ
БОЛГОН ХУУЛЬЧИЛСАН**

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Чадахуйн зарчим /мерит/” буюу Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх тухай ойлголт шинэчлэгдсэн.

Албан тушаалын
сул орон тоог
нөхөх

- Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас уг орон тоог нөхнө /27.1.1/

Төрийн жинхэнэ
албан хаагчийг
дэвшүүлэх,
бууруулах

- Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ /52.2/
- Ажилласан жилийн 50%-ийг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно. /26.3/

Хэрэгжилтийн
хяналт

- Төрийн албаны зөвлөл чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийнэ /66.1.4/

ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ: ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ

Хуулийн 33.2 дахь заалт.

Төрийн жинхэнэ албаны шалгалт доор дурдсан төрөлтэй байна.

33.2.1.ерөнхий шалгалт

Төрийн албаны ерөнхий шалгалтыг хэнээс авах вэ?

- Төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй иргэдээс

33.2.2.тусгай шалгалт

Төрийн албаны тусгай шалгалтыг хэнээс авах вэ?

- Энэ хуулийн 27.1.1, 27.1.2-т заасан төрийн албан хаагчаас
- Энэ хуулийн 27.1.3-т заасан нөөцөд байгаа иргэдээс

- 27.1.1. төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд:

төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс;

- 27.1.2. төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан Тохиолдолд:

тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;

- 27.1.3.төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо

энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс, боломжгүй бол нээлттэй сонгон шалгаруулалтаар;

27 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилохдоо дараах зарчмаар томилно. Үүнд: төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу

ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ: ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

Хэнээс авах вэ

Төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, хуульд заасан **нийтлэг шаардлагыг** хангасан иргэдээс авна.

Хэзээ авах вэ, нөөцөд байх хугацаа хэд вэ

Жилд нэгээс доошгүй удаа авна, **нөөцөд 3 жил байна.**

Хуульд заасан нийтлэг шаардлага гэж юу вэ

Монгол улсын иргэн, дээд боловсролтой, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж байгаагагүй, монгол хэлний бичгийн болон ярианы бичгийн чадвартай, сэтгэцийн өвчин эмгэггүй, /эрэгтэй бол/ цэргийн алба хаасан байна. /22 дугаар зүйл/

ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ: ТУСГАЙ ШАЛГАЛТ



Албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд хуульд заасан журмын дагуу албан хаагч болон иргэдээс авна.

33.5. Төрийн жинхэнэ албаны шалгалт нь сорил, ярилцлага болон бусад хэлбэртэй байна.

33.6. Төрийн жинхэнэ албаны шалгалт доор дурдсан агуулгатай байна:

33.6.1 .удирдан зохион байгуулах чадварыг шалгах;

33.6.2 .дүн шинжилгээ хийх чадварыг шалгах;

33.6.3 .асуудал шийдвэрлэх чадварыг шалгах;

33.6.4 .манлайлах чадварыг шалгах;

33.6.5 .монгол хэлний ярианы болон бичгийн чадварыг шалгах;

33.6.6 .багаар ажиллах чадварыг шалгах;

33.6.7 .бусад.



Сул орон тоо гарсан тухай бүрд авна.

Тусгай шалгалтын хамрах хүрээ

Ангилал	Зэрэглэл	Албан тушаал
Тэргүүн түшмэл	ТЗ-14	Яамны ТНБД, Ажлын албаны дарга
	ТЗ-13	Агентлагийн дарга
Эрхэлсэн түшмэл	ТЗ-12	Яамны газар, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал
	ТЗ-11	
	ТЗ 10	
Ахлах түшмэл	ТЗ-9	Яамны тасгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал
	ТЗ-8	
	ТЗ-7	Яамны ахлах мэргэжилтэн
Дэс түшмэл	ТЗ-6	Яамны мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал
	ТЗ-5	
	ТЗ-4	Яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал
Туслах түшмэл	ТЗ-3	Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах албан тушаалууд
	ТЗ-2	
	ТЗ-1	

Тусгай шалгалт нь шатлан дэвших зарчмын дагуу




ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ: ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ШАТЛАН ДЭВШҮҮЛЭХ, БУУРУУЛАХ

- **Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ /52.5/**
- *Ажилласан жилийн 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг **үйл ажиллагааны үр дүн,** мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно /26.3/*



26.4.Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газрын саналыг харгалзан төрийн албаны төв байгууллага батална. Албан тушаалд шатлан дэвшүүлж томилоход энэ журмыг баримтална.

ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ: ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА-МЕРИТ ЗАРЧИМ

Ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын *50 хувийг хангасан* төрийн албан хаагчийг *үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршдагаа, ур чадварыг* харгалзан хугацаанаас нь өмнө шатлан дэвшүүлж болно.



ДУГНЭЛТ




ТӨРИЙН АЛБАНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ОДООГИЙН ТОГТОЛЦОО

ДУГНЭЛТ



Шинэчлэн найруулсан
Төрийн албаны тухай
хуулиар:



ДУГНЭЛТ

- Төрийн жинхэнэ албаны тусгай шалгалт (тухайн албан тушаалын) нээлттэй бус хязгаарлагдмал шинжтэй болсон
- Яамны тасгийн дарга, түүнээс дээшхи удирдах албан тушаалын сонгон шалгаруулалт **ЗӨВХӨН** төрийн жинхэнэ албаны хүрээгээр хязгаарлагдсан.
- **Хувийн хэвшил, төрийн бус байгууллагад** ажиллаж байгаа чадахуйн зарчим (мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага)-ыг хангасан иргэн удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орох боломжгүй болсон.

ДҮГНЭЛТ

- Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх ба туслах албан тушаал (*ахлах шинжээч, шинжээч, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал*)-ын сул орон тоог тухайн байгууллагад ажиллаж байгаа, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас сонгон шалгаруулах боломжгүй тохиолдолд нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаар хуульчилсан.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ГЭЖ ЮУ ВЭ, АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ БАТЛАХ ЖУРАМ:

23.4.Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.3-т заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.

23.5.Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.

1. Боловсруулах:

ТАЗ-өөс боловсруулсан журамд нийцүүлэн боловсруулна.

2.Зөвшөөрөл авах:

Төрийн албаны зөвлөл хянана

2.Батлах:

Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд өөрчлөлт оруулахыг хориглоно.

Нэмэгдсэн шинэ зохицуулалт:ашиг сонирхлын зөрчлийн талаарх танилцуулга, албан тушаал бууруулах, дэвшүүлэх, шилжүүлэх талаарх танилцуулга

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

- Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 23.3 Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг Төрийн албаны төв байгууллага батална гэж заасан.
- Дээрх дурдсан нөхцөл шаардлагуудыг үндэслэн төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг шинээр боловсруулж батлах шаардлага үүсээд байна.
- Шинэчлэн боловсруулсан төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг баталж мөрдөх нь Монгол улсад мэргэшсэн, тогтвортой, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

ШҮҮХ

Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан маргааныг хянан шийдвэрлэх

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтлөх
Төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих
Төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах

БУРУУТАЙ АЛБАН ТУШААЛТАН

Хууль бусаар халсантай холбогдуулан төрд учирсан хохирлыг нөхөн төлөх

Шинэ зохицуулалт: төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ШИНЭЭР ОЛГОХ ТУСЛАМЖ, НЭМЭГДЭЛ ХӨЛС

Шинэ зохицуулалт

60.1. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журам

1. Буцалтгүй тусламж авах алба хаагчаас төрийн улс төрийн албан хаагч хасагдаж, төрийн үйлчилгээний албан хаагч нэмэгдсэн.

1. Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг шинэчлэх

60.3.Төрийн албан хаагчид энэ хуулийн 60.2-т заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгох нөхцөл, журам

1.Амь нас хохирсонтой холбоотой буцалтгүй тусламж олгох төрийн албан хаагчийн хүрээ улс төрийн болон үйлчилгээний албан хаагчаар нэмэгдсэн

2.Амь нас хохирсонтой холбоотой буцалтгүй тусламжийн хэмжээ 36-аас 60 сар болж нэмэгдсэн

Тайлбар: Төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэний амь насанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан хохирол учруулсан бол энэ хуулийн 60.2-т заасан буцалтгүй тусламжийг түүний ар гэрт мөн адил олгоно.

Буцалтгүй тусламжтай холбоотой тодотгол

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ШИНЭЭР ОЛГОХ ТУСЛАМЖ, НЭМЭГДЭЛ ХӨЛС

Шинэ зохицуулалт

Төрийн захиргааны албан хаагчид



1.Хөдөлмөрийн тухай хуульд
заасан нэмэгдэл хөлс шинээр
нэмж олгоно.
/ИЛҮҮ ЦАГИЙН ХӨЛС/

Төрийн үйлчилгээний албан хаагчид



1.Төрийн алба хаасан хугацааны
нэмэгдэл авна.
2.Өндөр насны тэтгэвэр
тогтоолгоход 36 хүртэл сарын нэг
удаагийн буцалтгүй тусламж
олгоно.

Шинэ зохицуулалт

Энэхүү шинээр орсон нэмэгдэл хөлс, буцалтгүй тусламжийн, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЭРХ ХЭМЖЭЭ

Тэтгэмж, тусламжийн нэр төрөл	ТАТХ-ийн шинэчилсэн найруулгад ЗГ-т эрх олгосон заалт	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журмын зохицуулалт	Журамлах шаардлага
Урамшуулал	ТАТХ-ийн 51.1.4-т төрийн албан хаагчид улирлын мөнгөн урамшуулал олгохоор, 51.2-т урамшуулал олгох журмыг ЗГ тогтоохоор; 2018-382, 2019-38	ЗГ-ын 1995/96 -р тогтоолын 6-р хавсралт “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”	Одоогийн журмыг хүчингүй болгож шинээр боловсруулна
Нөхөх төлбөр	ТАТХ-ийн 59.1-д 8 төрлийн нөхөх төлбөр 59.2-т нөхөх төлбөр олгох журам, хэмжээг ЗГ тогтоохоор; СС-ын 2018 оны 301 албан томилолтын зардлын хэмжээ	Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйл; ЗГ-ын 1995/ 218 -р тогтоолын 1-р хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” + ЗГ-ын 2004/112-р тогтоолын хавсралт “ТАХ-д тусламж олгох нөхцөл журам”-ын 5.б дэд заалт;	Одоогийн журмыг хүчингүй болгож шинээр боловсруулна
Нэг удаагийн буцалтгүй тусламж	ТАТХ-ийн 60.1-д тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн тусламж олгох цалингийн дундаж хэмжээ, олгох журмыг ЗГ тогтоохоор; 2019-07	Төрийн албаны тухай хуулийн 30.2; ЗГ-ын 2014 /405 дугаар тогтоолын хавсралт “ТЖА-д нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”	Одоогийн журмыг хүчингүй болгож шинээр боловсруулна
	ТАТХ-ийн 60.2-т ТАХ-ын амь нас хохирсон тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгох, 60.2-т тусламж олгох журмыг ЗГ;	Төрийн албаны тухай хуулийн 30.3; ЗГ-ын 2004/112-р тогтоолын хавсралт “ТАХ-д тусламж олгох нөхцөл журам”-ын 4 дэх заалт;	Одоогийн журмын заалтыг хүчингүй болгож шинээр журам боловсруулна
Орон байрны дэмжлэг	ТАТХ-ийн 61.1.5-д ТАХ орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх баталгааг, 61.2-т баталгааг эдлүүлэхтэй холбогдсон журмыг ЗГ:	ТАТХ-ын 27.1.5-Төрөөс орон байраар хангагдах баталгаа, ЗГ-т энэ баталгааг зохицуулах эрх олгоогүй	Шинээр журам боловсруулна
Дүрэмт хувцас	ТАТХ-ийн 63.1-д ТАХ хуульд заасны дагуу дүрэмт хувцас хэрэглэж болно, 63.2-т дүрэмт хувцасны эдэлгээний хугацаа хэрэглэх журмыг ЗГ тогтоохоор.	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ТАТХ-д дүрэмт хувцастай холбоотой заалт байхгүй. Салбарын хуулиар эрх олгосны дагуу ЗГ болон Агентлагийн дарга тогтоож байгаа	Шинээр журам боловсруулах шаардлагагүй

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЭРХ ХЭМЖЭЭ

ТАТХ-ийн 59.1-д 8 төрлийн нөхөх төлбөр 59.2-т нөхөх төлбөр олгох журам, хэмжээг ЗГ тогтоохоор;

59.1.Төрийн албан хаагчид дараахь нөхөх төлбөрийг олгоно:

59.1.1.албан томилолтын зардлыг;

59.1.2.албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн тохиолдолд батлагдсан нормативын дагуу гарсан зардлыг;

59.1.3.гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор ажиллахаар томилогдсон албан хаагчид тээврийн хэрэгсэл, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст тээврийн хэрэгсэл, ачаа тээшийн зардлыг;

59.1.4.төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

59.1.5.төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөгжлийн бэрхшээлтэй болж, хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлын тодорхой хэсгийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх, зөрүүг улсын төсвөөс нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

59.1.6.ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгох;

59.1.7.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах;

59.1.8.хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр.

ШИНЭЧИЛСЭН ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ЖУРАМ

- 1. “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох журам”**
- 2. “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”**
- 3. “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”**
- 4. “Албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас нь хохирсон төрийн албан хаагчийн ар гэрт нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”**
- 5. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид ТАХ хугацааны нэмэгдэл олгох журам”**
- 6. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”**
- 7. “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”**
- 8. “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл хөлс олгох нийтлэг журам”**
- 9. “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл хөлс олгох нийтлэг журам”**
- 10. “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох нийтлэг журам”**
- 11. “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”**


Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох журам

Гол асуудал	ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ	ЖУРМЫН ТӨСӨЛД ХЭРХЭН ТУСТАХ
Эрх зүйн зохицуулалтын ялгаатай байдал	Төрийн байгууллагууд ТАХ-д олгох улирлын урамшууллыг хөдөлмөрийн дотоод журамдаа тусган хэрэгжүүлж байна. (ЗГ-ын 1995/96-р тогтоол)	Агуулгыг хэвээр хадгалж шинэ журмын төсөлд тусгасан
	Боловсролын тухай хуулийн 43.4, ЗГ-ын 2017/146-р тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам” , Эрүүл мэндийн тухай хуулийн 30.5, ЗГ-ын 2012/150 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох журам” -ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.	Боловсрол, Эрүүл мэндийн салбарын тусдаа хуулийн зохицуулалттай тул одоо байгаа журмыг хөндөхгүй, хэвээр үлдээнэ
Урамшууллын хэмжээ	<ul style="list-style-type: none"> улирлын ажлын үр дүнгийн урамшууллын дээд хязгаарыг үндсэн цалингийн 40 хувиар тогтоож байгаа Практикт төсвийн боломжтой уялдуулан гэрээний үнэлгээгээр авсан оноог харгалзан олгодог 	<ul style="list-style-type: none"> Үндсэн цалингийн 40%-ийн хязгаарлалтыг хэвээр үлдээнэ Батлагдсан төсөвтөө багтаан энэ хэмжээг нэмэх эрхийг төсөв захирагчид олгоно
Бусад нөхцөл шалгуур	ТАЗ-өөс баталсан Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журамд заасан нөхцөл шалгуурыг баримтлах ёстой боловч практикт хангалтгүй байдаг	<ul style="list-style-type: none"> ТАЗ-ийн журамд заасныг баримтлах Цаг ашиглалт 90 хувиас дээш байх Сахилгын шийтгэлтэй байх хугацаа дуусаагүй бол олгохгүй байх Шаардагдах зардлыг төсөвт хэрхэн тусгах

“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”

Нөхөх төлбөрүүд	ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ	ЖУРМЫН ТӨСӨЛД ХЭРХЭН ТУСГАХ
Албан томилолт	Төрийн захиргаа, Төрийн үйлчилгээ, Төрийн тусгай албан хаагчдад ялгавартай зохицуулалт үйлчилдэг (Жнь: урьдчилан олгох, баримт бүрдүүлэх, тариф г.м)	<ul style="list-style-type: none"> • Ялгаатай байдлыг арилгах
Унаа, хоол, байр, түлш	<ul style="list-style-type: none"> • Журмаар зохицуулсан зохицуулалт байхгүй. • Унаа хоолны хөнгөлөлтийг нийтлэг олгодог боловч хэмжээг нь янз бүр тогтоосон байдаг 	<ul style="list-style-type: none"> • Журамд тусгана • Унаа хоолны тариф тогтоох
Эмчилгээний төлбөр, замын зардал	Төрийн албан хаагчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлөх (59.1.4, 59.1.5), төрийн албан хаагч ээлжийн амралтаараа төрсөн нутаг явах болон сувилалд сувилуулахаар явахад замын зардал нөхөн олгох (59.1.6), төрийн албан хаагчид олгох эмчилгээний зардлын нөхөн төлбөр (59.1.7)	<ul style="list-style-type: none"> • Журмын төсөлд нэмж тусгав.
Бусад	Гадаад улс орон эсхүл өөр аймаг хотод шилжин ажиллах, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах	<ul style="list-style-type: none"> • Одоогийн журмын зохицуулалтыг хэвээр хадгалах

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ШИНЭЭР ОЛГОХ ТУСЛАМЖ, НЭМЭГДЭЛ ХӨЛС


**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2011 оны 06 сарын 14 өдөр Дугаар 138 Улаанбаатар хот

Зардлын хэмжээг шинэчлэн
тогтоох тухай


Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтийг харгалзан төсвийн норм, нормативыг шинэчлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлттэй уялдуулан улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг суманд 18,000 төгрөг, аймгийн төвд 29,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 35,500 төгрөгөөр, төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг суманд 12,000 төгрөг, аймгийн төвд 14,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 16,000 төгрөгөөр тус тус тогтоосугай.


Хоёр. Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгохыг төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвөөс санхүүждэг байгууллагуудын эрх баригч нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Энэхүү тушаалыг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтоосугай.

Дөрөв. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2006 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 64 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.БАЯРЦОГТ

08 0153



**МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 12 сарын 28 өдөр Дугаар 501 Улаанбаатар хот

Зардлын хэмжээг шинэчлэн
тогтоох тухай

Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтийг харгалзан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийн зардлыг суманд 12,000 төгрөг, аймгийн төвд 14,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 16,000 төгрөгөөр, байрны зардлын хэмжээг суманд 14,500 төгрөг, аймгийн төвд 36,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 53,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.
2. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгох, шаардлагагүй тохиолдолд төрийн албан хаагчид байрны зардал төсөвлөн олгохгүй байхыг төсөвт байгууллагын болон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт зөвлөсүгэй.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2011 оны 6 сарын 14-ний өдрийн 132 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

 Ч.ХҮРЭЛБААТАР

“Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”

Гол асуудал	ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ	ЖУРМЫН ТӨСӨЛД ХЭРХЭН ТУСТАХ
Эрх зүйн зохицуулалтын ялгаатай байдал	Хуульд заасны дагуу боловсрол, эрүүл мэндийн салбарын ТҮ ангиллын албан хаагчид 36 хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж авч байна	Одоо мөрдөгдөж байгаа зохицуулалт хэвээр хадгалагдана.
	Боловсрол, эрүүл мэндийн салбараар бусад ТҮ ангиллын албан хаагчид тэтгэвэрт гарах бол Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1-ийг үндэслэн 3-6 сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж авч байна	Төрийн албаны тухай хуулиар ялгавартай байдлыг арилгасан тул 36 хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжид 2020 оноос эхлэн хамрагдана.
	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу Төрийн тусгай (ТТ) албан хаагчид 36 сарын цалин хөлстэй тэнцэх нэг удаагийн тэтгэмж авч байна.	<ul style="list-style-type: none"> • Хуульд өөрөөр заасан тул энэ журамд хамаарахгүй. • ЗГ-ын 2011 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам” -ыг баримтална.
	Хуульд өөрөөр заасан зохицуулалт: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 291.1.1, Соёлын тухай хуулийн 22.1.1, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 21.1.3	Хэрэв Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад нь зориулж нэг удаагийн тэтгэмж олгох талаар заасан бол төрийн албан хаагч тэдгээр тэтгэмжийн аль илүүг сонгох эрхтэй ба энэ тохиолдолд тэтгэмжийг давхардуулан олгохгүй.
Бусад нөхцөл шалгуур	Төрийн албанд ажилласан жил, төрийн албанд ажилласнаар тооцох хугацаа	<ul style="list-style-type: none"> • Доод тал нь 5 жил төрийн албан хаагчаар тасралтгүй ажилласан байх • Төрийн албанд ажилласнаар тооцох ажил, албан тушаалыг бүх ТА-дад адил үйлчилдэг байх

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шинэ зохицуулалт: Хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр

Төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах:

35 дугаар зүйл. Хариуцлага

Төрийн жинхэнэ албан тушаалд тавих шаардлага, томилох шалгуур, сонгон шалгаруулах журам, томилох хугацаа, хориглох заалтыг зөрчсөн төрийн албан хаагчийг төрийн албанд **гурван** жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр хална.

48 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчид

**сахилгын шийтгэл
ногдуулах**

48.1.4. Төрийн албанд **гурван** жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах

76 дугаар зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох

76.6. Энэ хуулийн 76.4, 76.5-д заасныг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд **гурван** жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас хална.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

42.1.Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ **түр орлон** гүйцэтгүүлж болно:

42.1.1.ээлжийн амралттай;

42.1.2.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй;

42.1.3.дотоод, гадаад албан томилолттой;

42.1.4.зургаан сар хүртэл хугацаагаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан;

42.1.5.удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа;

42.1.6.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;

42.1.7.албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсантай холбоотой асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй;

42.1.8.албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан;

42.1.9.албан хаагч өөр албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон;

42.1.10.албан хаагч нас барсан.

Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоол хүчингүй болно.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

43.1.Энэ хуулийн 43.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан **14 хоногийн дотор гаргана.**

43.3.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ:

43.3.1.байгууллагын даргын албан үүргийг түүний дэд дарга, орлогч түр орлон гүйцэтгэх;

43.3.2.дэд дарга, орлогчгүй, эсхүл эзгүй тохиолдолд байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх;

43.3.3.энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

43.3.4.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх.

Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоол хүчингүй болно.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТААС...

1. төрийн жинхэнэ албан хаагчийг ямар тохиолдолд төрийн албанаас түр чөлөөлөх вэ?

46.1.1. хуульд өөрөөр заагаагүй бол биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 3 сараас дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон;

46.1.2. зургаан сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон;

46.1.3. цэргийн жинхэнэ алба хаах болсон;

46.1.4. гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан.



ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ

Стратеги төлөвлөгөө

- Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.
- Төсвийн шүүд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор **Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө** боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.
- **Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө**

Хуулийн Арван гуравдугаар бүлэг

Олон нийтийн хяналт

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг **Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.**
- Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батална.

Төрийн албаны зарчмын өөрчлөлт

Хэвээр үлдсэн

- 1/ ард түмэнд үйлчлэх
- 2/ мэргэшсэн тогтвортой байх
- 3/ ил тод байх
- 4/ захирах, захирагдах ёсыг баримтлах

Тодотгосон

- 1/ Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах

Хасагдсан

- 1/ Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах
- 2/ Төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах

Шинээр орсон

- 1/ Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам эвслийн үйл ажиллагаанаас ангид байх
- 2/ төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах
- 3/ ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх

Зарчим-Хэм хэмжээ

Хасагдсан зарчим:

Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах

Төрийн албаны шинэ хуулийн зохицуулалт

50.1. Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан **буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.**

50.2. төрийн албаны төв байгууллага хяналт тавина



НЭМЭГДСЭН ЗАРЧИМ

“Төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах”

- “**Чадахуйн зарчим /мерит/**”: иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах /3.1.3/
- Төрийн захиргааны албан тушаалд чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг **хамгийн сайн хангасан хүнийг** томилно. /26.1/
- Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон **албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.** /23.5/



НЭМЭГДСЭН ЗАРЧИМ

”Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх”

Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг /37/

- Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа **улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх;**
/37.1.4/
- Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар **зөвхөн албан ёсны байр суурийг** илэрхийлэх;
/37.1.10/

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл /39

- Улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон **шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;**
/39.1.5/
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон **цахим хуудас, нийгмийн сүлжээний** хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар **албан бус байр суурь**, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх; /39.1.13/

НЭМЭГДСЭН ЗАРЧИМ “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх”

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл /39/

- Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах /39.1.4/
- Албан тушаалын бүрэн эрхээ шашны эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах /39.1.8/
- Сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах /39.1.6/
- Албан бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших /39.1.11/



Хуулийн ач холбогдол:

- улс төрөөс хараат бус, ил тод, хариуцлагатай төрийн албаны эрх зүйн үндэс бүрдэх;
- төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаах шалгуур зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг, чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог болох нөхцөл баталгаажих;
- мэдлэг, чадвартай иргэд нээлттэй өрсөлдөөнөөр төрийн албанд орох боломжийн зэрэгцээ шатлах дэвших тогтолцоог төрийн албанд нэвтрүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах.

**АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА**

2018.11.07